



**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Д/д	Ста бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1	Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг олгож эхлэх	-	Цахимаар олгосон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	2	Орон нутгийн хэмжээнд цахимаар гэрчилгээ олгож эхлээгүй байгаа тул хэрэгжээгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай.	-
1.2	Тоон гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	100	100	2025 оны 12 дугаар сарын 1-ээс 6 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд 6006 тоон гарын үсэг олгосон буюу хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн.	100
1.3	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	2	2	Гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг авсан иргэдийн тоон судалгаанд үндэслэн Улсын бүртгэгч нарын хөрвөх чадварыг болон ажлын үр дүнг сайжруулах, суманд үзүүлж байгаа улсын бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 03 сард эхний 8 сумын	100
			Шинжилгээний үр дүнд хэрэгжүүлсэн хэмжээний тоо	1	1		

						улсын бүртгэгчдийг, 2025 оны 05 сард үлдсэн 11 сумын улсын бүртгэгчдийг гадаад паспортын бүртгэл хийх дадлагын удирдамжийн дагуу дадлагыг хийлгүүлсэн бөгөөд өнөөдөр 20 сумын улсын бүртгэгчид бүгд бүртгэл хийж байна. Гадаад паспортын бүртгэлийн эрх олгогдсоноор 2025 оны 03 дугаар сараас 2025 оны 06 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд хөдөө суманд гадаад паспортын 302 бүртгэл бүртгэгдээд байна.	
1.4	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх	-	Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо	4	4	Улсын Бүртгэлийн ерөнхий хуульд 4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд 12, ХЭУБТХ-д 6, мөн журмын төсөлд 3 саналыг тус тус хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.	100
1.5	Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд өөрчлөх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж дуусгах	-	Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаяг шинэчлэгдсэн хувь	80	100	Энэ арга хэмжээний хүрээнд УБЕГ-ын МТГ-аас хилийн цэс өөрчлөгдсөний дагуу багаас багт шилжсэн хаягийн судалгааг жагсаалтаар авсан ба уг жагсаалтын дагуу иргэний бүртгэлийн санд тухайн хаягууд дээр хичнээн иргэн бүртгэлтэй байгаа талаарх судалгааг гаргаж байна.	50
1.6	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх	-	Улсын бүртгэлийн цахим машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо	4475	4500	Тус хэлтэст 2022 оны 3 сард бүртгэлийн Дөт киоск машиныг байршуулан иргэдэд үйлчилж байгаа ба	100

						2025 оны 06 дугаар сарын 12-ны байдлаар 7970 лавлагаа үйлчилгээ авсан байна.	
1.7	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх		-Бэлтгэсэн Контентын тоо	25	25	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор 12 удаагийн контент бэлтгэж, түгээсэн байна.	48
1.8	Иргэний үнэмлэх хэвлэлтийг орон нутагаа авах санал хүргүүлэх	-	Саналын тоо	0	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт 5 дугаар сарын 26-ны 13/474 тоот албан бичгээр үйлдвэрийг байгуулж ажиллуулахад хэлтэс болоод орон нутгийн зүгээс бэлтгэл зохион байгуулалтын ямар ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байх шаардлагатай талаар холбогдох мэдээллүүдийг авах хүсэлтийг хүргүүлэн ажиллаж байна.	50
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Иргэний улсын бүртгэл хөтөлсөн хувь	100	100	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 7318 бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан бол Эд хөрөнгийн нийт 4960 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалж байна.	100
			Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн хувь	100	100		
			Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн хувь	100	100		

						Тайлант хугацаанд хуулийн этгээдийн нийт 1104 бүртгэл бүртгэгдсэн байна.	
2.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх	-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй орсон, алдаатай орсон мэдээллийг засч оруулсан тоо;	41	400	1. Бүртгэлийн явцад цахимжуулалтын алдаанаас мэдээллийн сан болон цаасан нотлох баримт хоорондоо зөрүүтэй байсан хувийн хэргүүдийг илрүүлж засуулахаар улсын бүртгэгч С.Баярмаа 12, А.Оюунсүвд 27, Т.Мягмарсүрэн 9 хувийн хэрэг нотлох баримтыг нятглан шалгаж тасгийн даргад архивчаар дамжуулан хүлээлгэн өгснөөс 100% зөрчлийг арилгасан байна.Харин эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж, цахим мэдээллийн санд зөрүүтэй хадгалагдсан, буруу дугаарласан, дутуу цахимжуулсан гэх мэт зөрчлийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн УАБ У.Золзаяа, улсын бүртгэгч С.Баярмаа, Т.Мягмарсүрэн, А.Оюунсүвд нар хамтран эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан сумын улсын бүртгэгч нарын 2023 оноос 2025 оны 2-р сар хүртэл бүртгэсэн 994 бүртгэлийг шалган Улсын бүртгэлийн	47,75

						ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2022-03-02-ны өдрийн 1500 дүгнэлтээр нийт 191 хувийн хэрэгт засвар өөрчлөлтийг хийж зөрчил арилгасан байна.		
2.3	Улсын байгууллагаас лавлагаа өгөх	бүртгэлийн мэдээлэл,	-	-Иргэнд олгосон тоо	5314	5400	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хуулийн байгууллагын албан бичиг 220, иргэн хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтэд 20 нийт 240 лавлагаа мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр лавлагаа хуулбар нийт 74 олгосон байна. Үүнээс лавлагаа 42, хуулбар 32 бүртгэсэн байна. Харин иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 3789 лавлагаа тус тус олгосон байна. Үүнээс иргэнд 2248, төрийн байгууллагад 540, хууль хяналтын байгууллагад 724 лавлагаа олгов.	42
				-Хууль хяналтын байгууллагад олгосон тоо	1545	1600		59
2.4	Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг үргэлжлүүлэх, нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг эхлүүлэх	-	-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;	8	9	Сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тухай тушаалын дагуу Баянхонгор аймгийн 6 сумын бүртгэгчдэд эд хөрөнгийн бүртгэлийн эрх нээгдсэн ба нийт 8 сум эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.Нэмж эрх	70
				Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумын тоо	12	13		

						олгуулахаар 2025 оны 13/282 тоот албан бичгийг ЭХЭУБГ-т хүргүүлсэн. Мөн Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх нэмж олгуулахаар 2025 оны 13/281 тоот албан бичгээр тус тус холбогдох судалгааг хүргүүлсэн.	
2.5	Хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	-	Эрсдэлийн төлөвлөгөө батласан тоо	1	1	УБЕГ-ын 2025 оны эрсдлийн төлөвлөгөөний төсөл болон журам өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ирүүлсэн өөрчлөлт оруулах төсөлд тус тус саналыг хугацаанд хүргүүлэн ажиллав.	50
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	83,3	90	Хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийн үнэлгээг хийх ажлын хэсгийн байгуулан ажиллаж байна.	
2.6	Аймгийн хэмжээнд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээгээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	-	Үйлчилгээний тоо	1221	1230	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, зорилтот бүлгийн иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор “Явуулын үйлчилгээ”-г 617 иргэнд үзүүлэв.	50,1
ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛ БОЛОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛНА.							
3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	88,8	100	2025 онд Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж төлөвлөгөөт бус шалгалт-2 хийгдсэн. 1450 бүртгэлд хяналт шалгалт хийсэн бол өргөдөл, гомдлын мөрөөр нийт 342 бүртгэлд хяналт шалгалт хийсэн байна. Хяналтын шалгалтын	50

						төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн 4 арга хэмжээг хэрэгжүүлээд байна.	
3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчлийг арилгасан хувь	100	100	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж, цахим мэдээллийн санд зөрүүтэй хадгалагдсан, буруу дугаарласан, дутуу цахимжуулсан гэх мэт зөрчлийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн УАБ У.Золзаяа, улсын бүртгэгч С.Баярмаа, Т.Мягмарсүрэн, А.Оюунсүвд нар хамтран эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан сумын улсын бүртгэгч нарын 2023 оноос 2025 оны 2-р сар хүртэл бүртгэсэн 994 бүртгэлийг шалган Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2022-03-02-ны өдрийн 1500 дүгнэлтээр нийт 94 хувийн хэрэгт засвар өөрчлөлтийг хийж зөрчил арилгасан байна	100
3.3	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлан, хэрэгжилтийг хангах	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	Зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд нийт 4 ажил тусгагдсанаас 2 ажлыг хийж гүйцэтгэлээ. 2 ажил нь	50

						хугацаа болоогүй хүлээгдэж байна. 1.Улсын бүртгэгч нарт “Зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүртгэлийн болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах ажил Нэгдсэн сургалтаар хийгдсэн бол, Цахим хөтөч сургалтад хамрагдсан ахлах ангийн сурагчдад мэдээлэл өгөх сургалт хийгдлээ. 2.Аймгийн төвөөс бусад 19 сумдын улсын бүртгэгч нарт үүрэг чилгэл өгч 2025 онд 16, 25, 45 нас болон төрөлт, нас баралт, гэрлэлт цуцлалт зэрэг хуульд заасан хугацаанд бүртгүүлэх бүртгэлүүдийг хугацаандаа бүртгүүлэх талаар 1 удаагийн онлайн сургалт хийлээ.	
ЗОРИЛТ 4. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
4.1	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2025” боловсруулан батлах, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	100	100	Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлдэг. Эхний хагас жилийн байдлаар хэлтсийн дотоод сургалт нийт 12 сургалт орохоор төлөвлөснөөс 11 удаагийн сургалт амжилттай зохион байгуулагдсан. Монгол бичгийн сургалтын багшийн ажлын зохицуулалтаас шалтгаалан хугацаандаа ороогүй байна. Хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг мөн тусгай	91,6

						хөтөлбөр батлан хэрэгжүүлж 5 дугаар сарын 8-9-ний өдөр зохион байгуулж ирц 100 хувьтай оролцсон.	
4.2	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр, 2025 оны төлөвлөгөөний холбогдох заалтыг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	86	100	2025 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл Улсын бүртгэлийн эх нотлох баримтын архивын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, мөн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой үйл ажиллагааны хөтөлбөрийг батлаад байна. Энэ хүрээнд Орон сууцанд хамрагдахаар 1 албан хаагч саналаа ирүүлснийг хүргүүлээд байна.	50
4.3	Монгол хэлний тухай хууль , Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	-	Хос бичгээр хөтөлсөн хувь	4	100	Хэлтсээ нийт 523 албан бичиг явсан ба 100 хувь Монгол бичгээр хослон хөтөлсөн.	100
4.4	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал” нь зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үзлэг оношилгоонд албан хаагчдын хамрагдсан хувь	-	50	ХЗДХЯ-аас санаачлан Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмч нарын үзлэгийг Хангайн бүсийн аймгуудад зохион байгуулсан ба тус хэлтсийн албан хаагчид гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн хамтаар 2024 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд нийт 56 хүнийг хамрууллаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд мөн энэ оны 4 сард Баянхонгор аймагт ажиллах	83,3

						үеэрээ салбарын алба хаагчдыг хэвтэн эмчлүүлэхээр 120 квот өгсний 20 квот манай хэлтэст оногдсон бөгөөд Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар албан хаагч түүний гэр бүлийн 9 хүн хэвтэн эмчлүүлээд байна.	
ЗОРИЛТ 5. НЭГЖИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ, ГҮЙЦЭТГЭЛД НЬ ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ							
5.1.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 11 сарын 25-ний өдрийн байдлаар 27 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 23, шийдвэрлэх шатандаа 4 өргөдөл байна. Өргөдөл гомдлын мэдээ, тайлан үнэн зөв гарган улирал тутам аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст мөн УБЕГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна.	85,1
5.2	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Хугацаатай, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	100	100	Хэлтсийн хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар ирсэн албан бичиг 458, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, албан даалгавар 17, дотоод албан	94,7

						бичиг 4 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 523 албан бичиг явуулсан байна. Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг ер системд бүртгэн хяналт тавин ажиллаж байна. Хэлтэст нийт 384 хариутай албан бичиг ирүүлсэн ба хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг 20 байна.	
5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	-	Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь;	98	100	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллахыг анхааруулж байнгын хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ямар нэгэн зөрчил илрээгүй, гомдол мэдээлэл ирээгүй байна. Үйлчилгээний стандарт мөрдөлтийн явцын талаар сар бүрээр нэгтгэж хамт олны мэдээллийн цагт 3 удаа танилцуулж хэрэгжүүлэхийг үүрэг болгон ажиллаж байна. Үйлчилгээний стандартын хэрэгжилтийг тооцож үзэхэд 92 хувьтай байна.	92
5.4	УБЕГ-ын даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	98,6	100	УБЕГ-ын даргын зөвлөлийн, мөн өргөтгөсөн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр нь хүлээн авч хэрэгжилтийн	100

	хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах					ханган ажиллаж байна. Тамгын газрын даргын шуурхай цахим хуралд тухай бүр нь бүрэн оролцсон. Үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь naranchimeg.a@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	
5.5	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Нууцын баталгаа авсан хувь	100	100	2025 оны гарсаар хэлтсийн нийт албан хаагчдаас гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотойгоор нууцын баталгааг нийт 37 албан хаагчаас гаргуулан авсан.2024 оны байгууллагын нууцын тайланг аймгийн Тагнуулын хэлтэст хугацаанд хүргүүлсэн. 2025 оны 5 сард шинээр албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон 1 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авч хууль тогтоомжийг тайлбарлан таниулж уншиж судлах үүргийг өгсөн болно. Нууцын тухай хууль тогтоомжоор сургалт мэдээлэл 1 удаа хийсэн байна. Мөн Аймаг, нийслэл ,сум дүүргийн ИТХ-ын нөхөн сонгууль болохтой холбоотойгоор 5 хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудаас мөн нууцын баталгааг авсан. Холбогдох	100

						сургалтыг зохион байгуулахаар бэлтгэж байна.	
5.6	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүрийн тоон мэдээг байршуулсан тоо	12	12	Улсын бүртгэлийн ерөнхий газарт сар бүрийн тоон мэдээг тухай бүр нь үнэн зөв гаргаж хугацаанд нь хүргүүлж нэгтгүүлсэн. Мөн Хэлтсийн bayankhongor.burtgel.gov.mn вэйб хаягийн сар бүрийн тоо мэдээ цэст болон хэлтсийн мэдээллийн самбарт 6 удаа байршуулсан болно.	100
5.7	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлийн тоо	3	4	УБЕГ-аас нэгдсэн байдлаар үүсгэн хөтлөж буй хэлтсийн вэйб хуудсанд хэлтсээс хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, зохион байгуулсан сургалт, цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд, бүртгэлийн тоон мэдээ, нээлттэй ажлын байрны зар болон цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулж иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлж ажиллаж байна.	100
			Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо	476	500	Аймагт үйл ажиллагаа явуулдаг FM радио болон телевизүүдэд мэдээ мэдээлэл өгөх, нэвтрүүлэгт оролцохоор аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн албатай хамтран ажиллаж байна. /Bayankhongor.burtgel.gov.mn / Тус хаягт тайлант хугацаанд 45 үйл ажиллагааг	

						сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд 274 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь “Архивч ажилд авах зар”, “Бүртгэлийн үйчилгээг Бямба гарагт” үзүүлэх зар мэдээллүүд тус тус байна.	
5.8	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах	Орон нутгийн төсөв	Санал тавьж шийдвэрлүүлсэн тоо	2	1	Хэрэгжих хугацааа болоогүй.	-
5.9	Байгууллагын тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх	-	Баримтыг заасан хугацаанд бүрэн шилжүүлсэн баримтын тоо	1	1	Хэлтсийн бичиг хэргийн ажилтан 2025 оны онцлог ажлуудын гэрэл зургийн цомгоос бүрдсэн тусгай төрлийн баримтыг архивын журмын дагуу бэлтгэн IY улиралд багтаан Төрийн архивын хэлтэст хуваарийн дагуу хүлээлгэн өгдөг тул хугацаа болоогүй. Хэрэгжилтээс хасуулж тооцуулах саналтай.	-
5.10	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	100	Төлөвлөгөөг нийт 14 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжүүлснээс 9 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй. Хэрэгжилт хангагдаагүй 1 арга хэмжээ байна.	77,8

ЗОРИЛТ 6. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

6.1	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих	-	Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо	147	147	Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn , сайтад сар бүр тогтмол байршуулан 68 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bavankhongqorburtgel.com сайтад тогтмол байршуулан 5 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.	100
			Хуулийн хэрэгжилтийн хувь	98,6	100	Хуулийн хэрэгжилтийн хувь 100 болно.	100

ЗОРИЛТ 7. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.

7.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээнд, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	27	18	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээнд 5, мэдээллийн самбарт 3 удаа байршуулж, олон нийтэд мэдээлэл 8 удаа байршуулж түгээсэн байна.	44,4
			Хэлтсээс энэ чиглэлээр бэлтгэсэн контентийн тоо	0	2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанл нэгдэж хэлтсээс 1 удаагийн Албан хаагчид Авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан авлигын эсрэг гэрэл түгээе,	50

--	--	--	--

-----oOo-----

		ирээдүйнхээ төлөө нэгдье, бид ёс зүйтэй төрийн албан хаагч, авлигын эсрэг нэгдье зэрэг уриалгыг илтгэн харуулсан контентийг бэлтгэн хэлтсийн пэйж хуудсанд байршуулж хэлтсийн нийт албан хаагчид хувийн фэйсбүүк хуудсаараа шэйрлэж олон нийтэд түгээн ажиллаж байна.	
--	--	---	--



Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс
Захиргаа
Дарга
Цэдэндамба Мөнхжаргал
2025.06.13 18:21

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ЦЭДЭНДАМБЫН МӨНХЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		58.75

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1	100	15
2.	Арга хэмжээ 2	100	10
3.	Арга хэмжээ 3	100	
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			12.5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	15
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	15
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	15
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14.7

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 58.75
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 12.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 14.7.
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	 оноо
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		85.95.

Үнэлгээ өгсөн:

Төсвийн шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

У.БОЛДХҮҮ

(огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Нэгжийн дарга:

БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ

(огноо)